



IV-VI/2021


Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 11



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого 14.1 хувиар өслөө

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2021 оны эхний хагас жилд 748.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс оноос 92.5 (14.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого, улирлаар, тэрбум төгрөг



Энэхүү өсөлтөд шуудангийн үйл ажиллагаанаас олсон орлого 4.8 (40.6%) тэрбум төгрөг, цахилгаан холбооны бусад үйлчилгээнээс олсон орлого 14.0 (35.1%) тэрбум төгрөг, утасгүй холбооны үйлчилгээнээс олсон орлого 64.8 (17.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2021 оны 2-р улиралд 398.2 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 47.9 (13.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн 2 дугаар улирлаар байдлаар

Үзүүлэлт	2019 IV-VI	2020 IV-VI	2021* IV-VI
Суурин утасны цэг, мян. шир	318.1	308.5	309.8
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мян. хүн	4 360.3	4 422.5	4 487.0
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид	891 624	900 728	941 888

Суурин утасны цэгийн тоо 2021 оны 2 дугаар улиралд 309.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (0.4%) мянган цэгээр өссөн байна. Энэхүү өсөлтөд төвийн бүсийн суурин утасны цэг 810.0 (3.8%) өссөн нь нөлөөлсөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2021 оны 2 дугаар улиралд 943.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 42.4 (4.7%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Кабелийн телевиз хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 22.1 (4.5) мянга, Орхон аймагт 6.2 (22.3%) мянга, Хөвсгөл аймагт 4.6 (16.1%) мянга, Дархан-Уул аймагт 3.3 (15.7%) мянган хэрэглэгчдээр өссөн нь нөлөөлөв.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 2021 оны 2 дугаар улиралд 4.5 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 64.5 (1.5%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 33.8 (1.5%) мянга, Баян-Өлгий аймагт 11.7 (11.7%) мянга, Ховд аймагт 8.2 (8.4%) мянга, Дархан-Уул аймагт 7.8 (6.8%) мянга, Увс аймагт 6.9 (7.3%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Интернэт хэрэглэгчдийн тоо 2021 оны 2-р улиралд 4.0 сая болж, үүнээс үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч 3.6 сая, гэрээт интернэт хэрэглэгчид 343.3 мянга байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 2021 оны 2-р улиралд 3.0 сая ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 сая ширхгээр (37.3%) буурсан байна. Энэхүү бууралтад дотоодын шуудан, илгээмж 1.8 сая (39.0%), улс хоорондын гарах шуудан, илгээмж 4.3 мянга ширхэгээр (9.3%) буурсан нь нөлөөлсөн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2021 оны эхний хагас жилд 496.0 мянган ширхэг бичиг, захидал, 152.7 мянган ширхэг боодол, 251.8 мянган ширхэг илгээлт, 107.0 мянган ширхэг буухиа, 341.7 мянган ширхэг бизнес захидал, 87.6 мянган ширхэг гибрид шуудан, 11.5 мянган ширхэг цахим худалдааны илгээмж, 1.6 сая ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.

Хүснэгт 2. Шуудангийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Шуудан илгээмжийн урсгал	Бүгд		Дотоод шуудан		Улс хоорондын гарах		Улс хоорондын орох	
	2020 I-VI	2021*I-VI	2020 I-VI	2021*I-VI	2020 I-VI	2021*I-VI	2020 I-VI	2021*I-VI
	мянган ширхэг							
Нийт шуудан, илгээмж	4 815.7	3 018.2	4 638.2	2 828.1	46.3	42.0	131.2	148.1
Бичиг захидал	515.1	496.0	458.8	453.3	21.2	9.0	35.2	33.7
Боодол	77.6	152.7	33.3	117.6	5.1	3.4	39.2	31.8
Илгээлт	103.3	251.8	54.7	187.5	11.3	17.2	37.3	47.1
Буухиа	62.0	107.0	33.8	59.0	8.7	12.5	19.6	35.5
Бизнес захидал	402.1	341.7	402.1	341.7	-	-	-	-
Гибрид шуудан	99.4	87.6	99.4	87.6	-	-	-	-
Цахим худалдааны илгээмж	9.7	11.5	9.7	11.5	-	-	-	-
Хэвлэл	3 546.3	1 569.8	3 546.3	1 569.8	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

- Суурин телефон цэг гэж нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг ойлгоно.
- Сансрын холбооны хэрэглэгчид сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.
- Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно.
- Гибрид шуудан гэж хэрэглэгчээс мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авч, хэвлэн дугтуйлан битүүмжилж хаягт эзэнд нь хүргэх шуудангийн илгээмж юм.
- Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно.
- Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмж юм.



Эх үүсвэр: ҮСХ, мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын

дарга Э.Эрдэнэсан

Утас: (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын,

статистикч О.Мандахзориг

Утас: (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212